

Агуулга

1. Төслийн товч танилцуулга	2
2. Байгаль орчны суурь судалгаа	3
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.	10
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.	12
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	14
7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ...	16
10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	17
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	18
12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	19
13. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	20
14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт,	20
15. Байгаль орчинд зарцуулсан төсөв.	21
16. Дүгнэлт	22
17. Хавсралт	

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Доргонт, Улаан ухаа нэртэй 269.28га бүхий MV-022121 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай нь Булган аймгийн Дашинчилэн сумын төвөөс зүүн хойш 65 км, Төв аймгийн Заамар сумын Заамарын нурууны зүүн хэсэгт буюу Туул голын зүүн эрэгт оршино.

Талбайн солбилцол нь:

Хүснэгт 1. MV-022121 тоот талбай: 269.28га

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 17' 55"	48° 8' 20"	7	104° 17' 17"	48° 8' 14.7"
2	104° 17' 51.9"	48° 8' 29.6'	8	104° 17' 17"	48° 7' 41"
3	104° 17' 50.9"	48° 8' 42.4"	9	104° 17' 41"	48° 7' 41"
4	104° 17' 40"	48° 8' 51"	10	104° 17' 41"	48° 7' 57"
5	104° 16' 29"	48° 8' 51"	11	104° 18' 5"	48° 7' 57"
6	104° 16' 29"	48° 8' 14.7"	12	104° 18' 5"	48° 8' 11"

Доргонт, Улаан ухаа алтны шороон орд нь металлогений хувьд Хойт Хэнтийн алтны бүсийн Заамарын хүдрийн дүүргийн баруун хойд жигүүр хэсэгт, Давхар уул-Бэрхийн хүдрийн зангилааны Улаан-Уулын хэтийн төлөв бүхий хүдрийн талбайд /УГЗ-200 ангиллаар/ хамрагдах бөгөөд Туул голын татамын, түүний зүүн дэнжийн алтны шороон ордуудын шууд доод үргэлжлэл хэсэгт оршдог.



Зураг 1. Уурхайн байршил зураг

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ

Дэд бүтэц

“Доргонот, Улаан ухаа” нэртэй талбайд байрлах уг орд нь засаг захиргааны хувьд Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Туул голын татамын хэсэгт байрлана.

Уур амьсгалын тойм

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Булган аймгийн Дашинчилэн сумын цаг уурын харуулын 2017 оны жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой.

Дашинчилэн сумын 2017 оны агаарын жилийн дундаж температур нутгийн ихэнх газраар өвлийн улиралд -9.7° -17.3°C , зуны улиралд 14.5° -21.1°C байдаг байна.




График 1. Дашинчилэн сумын 2017 оны агаарын хамгийн их, бага температур

Хөрсний температур: Дашинчилэн сумын хөрсний гадаргын температурын 2017 оны байдлаар хамгийн их халсан сар 7-р сард 28.4 градус дулаан, хамгийн их хүйтэрч хөлддөг $-12,7$ градус / Дашинчилэн харуул станц/ хүйтэрч байсан. Хөлдөлтийн гүн жил бүр харилцан адилгүй байдаг ба дунджаар 200 см хүрч хөлддөг. 11 дүгээр сарын I-10 хоногт хөрс хөлдөж эхлэдэг бөгөөд 2 дугаар сарын I-10 хоногт бүрэн хөлдөж дуусдаг. Хавар 3 дугаар сарын III-10 хоногоос хөрсний өнгөн үе гэсэж, 4 дүгээр сарын II-10 хоногоос 5 дугаар сарын II-10 хоногийн хооронд хөрс бүрэн гэсэж дуусдаг.




График 2. Дашинчилэн сумын 2017 оны хөрсний дундаж температур

Хур тунадас:

Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Дашинчилэн сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 0.3-1.6 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 2.5-5.3 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундажаас бага байна.



График 3. Дашинчилэн сумын 2017 оны дундаж хур тунадасны нийлбэр

Агаарын даралт ба салхи

Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Сумын хувьд монголын хамгийн их салхитай байдаг нутаг юм. Энэ нь манай орны хойд ба өмнөд зүгийн агаарын урсгалын хооронд оршдог учраас их салхитай байдаг. Агаарын 1 дүгээр сарын дундаж даралт нутгийн баруун хойд хэсгээр 846-850 гПа, бусад нутгаар 844- 846гПа. Харин 7 сарын байдлаар 842-844 гПа байдаг байна. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 26, 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10-аас дээш, явган шуургатай өдрийн тоо

жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 25 м/с хүрч байсан.

Булган аймгийн уур амьсгалын өөрчлөлт, хандлага

Булган аймагт 1941 оноос анх цаг уурын ажиглалтыг системтэй хийж эхэлсэн бөгөөд 16 сумтай үүний 6 суманд цаг уурын өртөө, 10 суманд ХААЦУ-ын харуул, томоохон голуудын дагуу 12 усны харуул ажиглалт судалгааг хийж байна. Энэхүү материалд сүүлийн 20 жилийн буюу 1997-2015 оны материалыг түүвэрлэн авч жилийн дундаж температурын хэлбэлзэл, их хүйтрэлт, дулааралтыг судалсан байна. Судалгааны материалд тэмдэглэгдсэнээр Булган аймгийн жилийн дундаж агаарын температур нь -0.9-1.6 градус байдаг. Сүүлийн жилүүдэд дулааралт эрчимтэй явагдаж температурын хэлбэлзэл аажим өсөж байгаа харагдаж байна.

Тус аймгийн ихэнх нутгаар 2000, 2001, 2008, 2010, 2012, 2015 онуудад нийт нутгийг хамарсан их хүйтэн өвөл болсон бөгөөд агаарын үнэмлэхүй бага температур -34,1-47,5 градус хүрч хүйтэрсэн байна. Энэ жилүүдээс 2001 оны 1-р сард үнэмлэхүй хамгийн бага температурын утга эвдэрч Хутаг, Орхонд -47,5 градус Тэшиг, Сэлэнгэд -46,1 градус, Баяннуурт -45,6 градус, Булган, Дашинчилэнд -42,3-42,4 градус хүрч хүйтэрсэн байна. Эдгээр онуудад их хүйтрэлт нь 9-14 хоног үргэлжилсэн бол 2012 оны 11 сарын сүүлээс 2013 оны 1 сарыг дамнан ихэнх нутгаар -30 градусаас хүйтэн хоногийн тоо нь 40 гаран хоног үргэлжилсэн байна.

1999, 2002, 2007, 2010, 2015 онуудад их халалт болж агаарын үнэмлэхүй их температур 1999 оны 7 сарын 2-р арав хоногт нийт нутгаар 35.5-43.5 градус хүрч 5-7 хоног үргэлжилсэн бол 2002 онд 7-р сарын 3-р арав хоногоос 8-р сарын 2-р арав хоног хүртэл 34.7-42.6 градус хүрч 40 гаруй хоног, 2007 онд 6-р сарын 1-р арав хоног болон 7-р сарын 3-р арав хоногт 32.0-40.6 градус хүрч 8-9 хоног үргэлжилсэн байна.

Гадаргын ус

Энэ дүүрэг нь уулс хоорондын Туул голын хөндий, гадаргуугаас 900-1000 м үнэмлэхүй өндөрт байрлана. Талбай нь Туул голын баруун эргийн дагуу байрлах Заамарын нуруунд харъяалагдах бөгөөд энэ нурууны хамгийн өндөр нь 1816 м хүрдэг боловч Заамарын нурууны ихэнх оргилуудын үнэмлэхүй өндөр нь 1500-

1700 м юм.

Талбайн баруун хэсгээр Бүрэнгийн нурууны олон салбарласан усан хагалбар бүхий нам уулс байрших бөгөөд ихэнх оргилуудын үнэмлэхүй өндөр нь 1200-1300 м юм. Хөндий болон жалгаас дээрх нурууны харьцангуй өндөршилт нь 100-150 м-ээс ихгүй байна.

Талбайн усан сүлжээ нь Туул гол болон түүний баруун, зүүн талын цутгалуудаас бүрдэх бөгөөд ордын талбайн хэмжээнд голын гольдрол нь тахиралдсан хэлбэр үүсгэдэг ба гольдролын өргөн нь 30-100 м хооронд хэлбэлздэг. Голын боргио хэсэгтээ 0.6 м, тайван урсгалтай хэсэгтээ 3 ба түүнээс дээш метр хүрдэг байна. Голын урсгалын дундаж хурд нь 0.5-1.5 м/сек байдаг.

Ажлын талбайд Туул голын баруун талын цутгалууд нь гүний хэрчигдэлд хүчтэй өртсөн бөгөөд жилийн ихэнх цагт усгүй байдаг бөгөөд тэдгээрийн урт нь 2-оос 10 хүртэл км хооронд үргэлжилдэг. Харин зүүн талын цутгалууд нь харьцангуй бага хэрчигдсэн усгүй сайр маягийг үүсгэх ба 4-өөс 5 км хүртэл үргэлжилдэг.

Гидрогеологийн нөхцөл

Орд нь гидрогеологийн мужлалаараа Хангай-Хэнтийн гидрогеологийн массивт хамаарагдах ба Туул голын ай савын доод хэсэг болдог.

Гүний ус нь үндсэндээ шүүлтүүрийн төрөлд багтдаг тиймээс ч тэдгээрийн нөөцийн тархалт ба горимын түвшин нь хур тундасжилтаас шууд хамааралтай болдог.

Геологи-гидрогеологийн нөхцөлийн дагуу ордын талбайн хэмжээнд дөрөвдөгчийн хурдсанд тархах гүний усны нэг давхрагыг олж тогтоосон болно. Том ширхэгтэй элсний мэшил, шавранцар дүүргэгчтэй нарийн үе агуулсан алаг цоохор өнгийн хайрга-сайргын хурдас нь ус агуулагч болдог. Хайргын усжилтын тархалт нь талбайд болон босоо зүсэлтэд жигд бус тархсан байна.

Ус агуулагч түвшингийн 0.4м-ээс 37.2м хооронд хэлбэлзэж, сул нэвчилтэй эллювийн гарлын занарын дээгүүр эсвэл формац хоорондын шаврын үеээр хязгаарлагдана.

Туул голын зүүн хажуугаар тархсан үндсэн чулуулгийн гарш нь ус агуулагч болж өгдөг. Энд талбайд тусгайлсан гидрогеологийн судалгааны ажил явагдаагүй болно. Туул голын дэнжийн ордын (704А талбай) өмнөх судалгааны

мэдээллээр усны ундрага нь аллювийн хурдас хуримтлалд 40 л/сек, ус нэвчилт 0,3-6,4 л/сек.м байна. Ус нь тунгалаг, гидрокарбонат-кальци-магнийн 0,4 г/л эрдэсжилттэй.

Олон жилийн цэвдэггүй, намаггүй, усан хангамж сайтай зэрэг нь ордыг ашиглах таатай орчныг бүрдүүлж байна.

Алт агуулагч давхрага нь нэг үеэс тогтох ба 42,0 м-ээс 44.8 м-ийн гүнд оршиж хөрс хуулалтын зузаан нь тархацын дагуу хөндийн эхээсээ адаг хүртэл улам ихэсдэг.

Ул суурийн доод хэсэг литологийн хувьд хянагдахгүй бөгөөд аллювийн гарлын цоохор өнгийн хайрга, аллюви-пролюви гарлын дайрга-үйрмэгийн хурдас болон доод палеозойн эллювийн ул суурийн чулуулга дээр хучиж тархсан байна. Алт агуулагч давхрагын дээд хилийг зөвхөн сорьцлолтын үр дүнгээр тогтооно. Үйлдвэрлэлийн ашигтай давхрагын зузаан нь 0,8 м-ээс 7,6 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Хуулах хөрс нь ургамалын үет хар шороон хөрс, шавранцар, хайрга-сайрга-дайрга, шавар, хайргын үеүүдээс тогтоно.

Ашиглалтын явцад ямар нэгэн химийн бодис хэрэглэхгүй тул усыг цэвэршүүлэх тусгай технологи шаардлагагүй юм. Олон жилийн цэвдэг байхгүй, хүйтний улиралд ул хөрс 2,2 м гүн хүртэл хөлдөнө. Ашиглах талбайд малын бэлчээрийн болон ой мод, бут ургамал байхгүй болно.

Ордын геологийн тогтоц

Доргонотын (Туулын татам хэсэг)алтны шороон ордын хайгуулын ажил явуулсан талбай нь Монгол-Өвөр Байгалийн атираат системийн Хойд-Хэнтийн захын өргөгдөлийн баруун хэсэгт, Баянголын гүний хагарлын бүсийн баруун-өмнөд жигүүрт оршино. Металлогенийн ангилалын хувьд энэ талбай нь Хойд Хэнтийн алтны хүдрийн металлогений бүсийн баруун өмнөд жигүүрт буюу Заамарын алтны хүдрийн зангилааны Доргонотын алтны дүүрэгт байрлана.

Геологийн тогтоцын хувьд ордын районд хожуу кембрийн өмнөх үеэс авахуулан орчин үеийн хүртэлх цаг хугацааг хамарсан хувирмал, вулканоген-тунамал болон сэвсгэр хурдас багтаж байна.

Давхарга зүй

Судалгааны талбайд давхаргазүйн хувьд хожуу кембрийн өмнөх үеээс

авхуулан дөрөвдөгчийн сэвсгэр хурдас чулуулаг өргөн тархсан байдаг.

Хараа группын Заамар формац тунамал-хувирмал чулуулаг нь хайгуулын талбайн геологийн тогтоцын хувьд хамгийн эртний чулуулаг болно.

Заамарын формац хурдас нь хэмэрлэг байдлаар үүссэн, салаавчилсан тогтоцтой шаварлаг занар, аркозын ба олигомикт элсэн чулуулгаас бүрдэнэ. Дүүргийн болон ордын геологийн тогтоц нь дунд кембрийн-доод ордовикийн насны (E2-O1гт) Заамарынформацын бялхмал-тунамал гарлын чулуулгаас бүрджээ.

Туулын татам хэсэгийн (Доргонот) алтны шороон ордын хэмжээнд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас өргөн тархалттай байдаг.

Дөрөвдөгчийн хурдас плейстоцен (O1) Хуурай хөндийн аллюви-пролювийн (ар) гаралтай шар-саарал өнгийн элс, хайрганы үетэй шавранцар, хайрганцар, шаварлаг элс бүхий дүүргэгч материалтай байна. Мөн татмын дээрхи хоёрдугаар (а1) ба түүнээс өндөр дэнжүүдийн (а2) аллювийн гаралтай ба элсэрхэг-шаварлаг дүүргэгчтэй хайрга, хайрганцар бүхий хурдас юм. Хурдасны зузаан 2-10м-т хэлбэлзэх бөгөөд Туул голын баруун, зүүн дэнж, Ар наймганы хөндийн адаг орчим энэ насны хурдас нь тархсан байна. Хайрганы ширхэгүүд дунд, том хэмжээтэй, сайн мөлгөржсөн байдаг.

Дөрөвдөгчийн хурдас плейстоцен-голоцен (O1-2) Уулын хажуу болон хормойн делювийн, делюви-пролювийн, делюви-коллювийн (бр) гаралтай, янз бүрийн хэмжээтэй хэмхдэс агуулсан шавранцар, элсэнцэр, шавар, дайрга, үйрмэг агуулсан элсэрхэг-шаварлаг хурдас болон татмын дээрхи нэгдүгээр дэнжийн аллювийн (а) хайрга, хайрганцар, элс, шаварлаг хурдаснаас бүрдэх бөгөөд литологийн бүтцийн хувьд хэмхдэст шавранцар, голын гольдролын гарлын хайрга, пролювиаль-делювиалийн үйрмэг, дайрга байх ба ихэнх тохиолдолд алтны агуулгатай байна. Заамарын хүдрийн бүсэд үйлдвэрлэлийн алтны агуулгатай давхарга агуулдаг боловч талбайн хэмжээнд алт илрээгүй болно. Татмын дээрх нэгдүгээр дэнжийн аллювийн хайрга, хайрганцар элс, шавар хурдасын зузаан нь 0.8-10.4 м байдаг.

Дөрөвдөгчийн хурдас голоцен (O2). Голын гольдрол, өндөр ба нам татмын аллювийн (а) гаралтай хурдас нь плиоцений хурдсыг хучиж байрлах ба шаравтар саарал, бор саарал өнгийн элсэрхэг-хайргархаг, хайрга, хайрганцар, элс, шавараас бүрдэнэ. Мөн пролювийн (р) гаралтай хөндийн элсэнцэр, шавранцар

хайрганцар, нуур-аллювийн (1а) гаралтай шавар, шавранцар, элсэнцэрээс тогтоно. Аллюви-пролювийн хурдас нь Заамарын алтны хүдрийн зангилаанд үйлдвэрлэлийн сонирхол татах хэмжээний алт агуулсан байдаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэхүү төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээг БОННУ-ний тайланд дараах байдлаар ангилан тодорхойлсон байдаг. Үүнд:

- Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ
- Гол сөрөг нөлөөллийн үнэлгээ.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дараах байрдлаар үзүүлсэн болно. Үүнд:

- Газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов.
- Ил уурхайн малталтын үед аюулгүй ажиллагаа дүрэм зөрчигдөх, технологийн буруу ажиллагаанаас үүдэн хөрсний нуралт, гулгалт зэрэг осол аваар үүсэж болзошгүй
- Уурхайн дотоод ба гадаад тээвэрлэлтийн үед их хэмжээний тоос дэгдэж ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсч газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Уурхайн хатуу хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.
- Агаар орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар

тодорхойлов.

Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй;

- Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов.
- Шөнийн цагаар уурхайн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

Уурхайн бүхий л үйл ажиллагаа нь “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад дүрэм зааврын дагуу явагдах ёстой. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учирч болзошгүй;

Гол сөрөг нөлөөлөл

Хөрсний дээд хэсгийн ялзмагт давхарга нь ургамлыг шим тэжээлийн бодисоор хангах гол эх үүсвэр болохоос гадна бохирдолын бодисуудыг саармагжуулах үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эвдрэлд орсон тохиолдолд газар дээрх хог хаягдлын хортой бодисууд нь гүний болон гадаргын усыг бохирдуулах нөхцөл бүрдэнэ.

Мөн хүний үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус гэх мэтийн үүсвэрүүд багтдаг.

Суурьшлын болон үйлдвэржилтийн бүс нутагт хүн амын өдөр тутмын хэрэглээнээс гарч буй ахуйн хаягдлаас шалтгаалж их хэмжээний хатуу хог хаягдал хөрсөнд хаягдан шингэж улмаар бохирдлын түвшинг нэмэгдүүлж эрүүл ахуйн байх ёстой түвшингээс хэтрүүлж ихэвчлэн хөрсний биологийн болон механик бохирдлыг бий болгодог. Харин уул уурхайн орчимд түүний техник хэрэгсэлээс ялгарах нефть, химийн хог хаягдлын үр дүнд хөрсөнд химийн болон

механик бохирдлууд түгээмэл ажиглагдана. Хөрсний бохирдол болон элэгдэл, эвдрэл нь хоорондоо салшгүй холбоотой байдаг.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэнэ.

2022 онд Байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах, түүнийг бууруулах, хянах чиглэлээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, БОМТөлөвлөгөөг баталсан байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулж батлуулан мөрдөж ажиллаж байгаа бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн доод хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

- Байгууллагын байгаль орчны үйл ажиллагааг оршин суугчдад таниулах уул уурхайн хандлагыг зөв чиглүүлэх
- Нөхөн сэргээлтийн ажлын үр дүн бүтээмжийг сайжруулан биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартад нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэх.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дүгээр сарын 18-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгов.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллалаа.

- Уурхайн бүх төрлийн машин механизмд үзлэг оношлогоо засварыг тогтмол хийж гүйцэтгэдэг бөгөөд засвар үйлчилгээг зориулалтын талбайд хийж гүйцэтгэв.
- Уурхайн замуудад усалгаа хийх замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж ажиллав .
- Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, баталсан маршрутаар явуулж хэвшүүлэх, салаа зам гаргуулахгүй байх зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээг байршуулан батлагдсан маршрутын дагуу тодорхой чиглэлээр тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгүүлэв .
- Шимт хөрсийг стандартын дагуу 0.3 метр зузаантайгаар хуулж зориулалтын талбайд хадаглах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд , бусад хөрс чулуулагтай холилдохгүй байх тал дээр анхааран зөв зохистой байршуулах, үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллав.
- Монгол-Ус ТӨҮГ-аар ус ашиглах дүгнэлтийг 2022 оны 06 дугаар сард гаргуулав
- Ус ашигласны төлбөрийг гэрээнд тусгагдсан үнийн дүнгээр төлж барагдуулав. Мөн үйлдвэрлэлийн ашиглах усыг бага түвшинд байлгах зорилгоор хаягдалын санг тогтмол засварлан ажиллав.
- Тунгаагуур нуурууд болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй усны эх

үүсвэрүүд зэргээс дээж авч бохирдолыг хянаж ажиллах замаар үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 болон 9 дүгээр сард Булган аймгийн БОШ Лабраторитой хамтран ажиллаж байна.

Бид батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус арга хэмжээний хүрээнд нийт 7 ажил төлөвлөсөн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 7 ажлыг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд биелэлт 100% хангагдсан болно.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.” MNS 5914-2008; “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” /MNS 5915-2008/; “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт /MNS 5916-2008/; “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/ стандартын дагуу төлөвлөгөөг гүйцэтгэсэн .

Хүснэгт-2 Нөхөн сэргээлтийн ажлын зардал болон гүйцэтгэл

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн тоо хэмжээ	гүйцэтгэл		зардал
				талбай	хувь	
1	Техникийн нөхөн сэргээлт гадаад овоолго	мян м ³				ҮАЗ
2	Техникийн нөхөн сэргээлт дотоод овоолго	га мян м ³	5,5 /3570/	5,5	100	ҮАЗ
	Биологийн нөхөн сэргээлт	га	3.2 /32,0/	3,2	100-	ҮАЗ

6.1 Техникийн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлтийн технологийг олборлолт, хөрс хуулалт, дотоод овоолго үүсгэлт зэрэг уулын ажлын технолонитой харилцан уялдуулж гүйцэтгэх нь хосолмол аргаар илүү их нөхөн сэргээлтийн ажил явуулах боломжийг бүрдүүлдэг. Үйлдвэрүүдийн уулын ашиглалтын систем нь хөрс хуулалт, техникийн нөхөн сэргээлтийг хамтад нь түвшний тээвэрлэлттэй дотоод овоолгоор зэрэгцүүлэн хийж, гадаргууг анх байсан хэлбэрт нь оруулдаг. Техникийн нөхөн сэргээлт хийхэд дараах үе шатууд байна.

1-р үе шат

Уурхайн ашиглалт явахаас өмнө ургамлын нөмрөг бүрхэвч болох шимт хөрсийг хуулж тусад нь овоолгоор хадгалж нөхөн сэргээлтийн хамгийн эхний үе шатны ажил хийгдэж эхэлдэг

2-р үе шат

Ашиглалтын үед үүссэн орон зайг дотоод овоолгоор дүүргэн “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008 стандартаар газрын гадаргын анхдагч хэлбэрт оруулж, тэгшлэн биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгоно.



Зураг-2-3 ТНС хийгдсэн талбайн өмнөх байдал



Зураг-4-5 Техникийн нөхөн сэргээлтийн явц



Зураг-6 Нөхөн сэргээлтийн дараахи байдал

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уурхайд ашиглагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчээр хийж гүйцэтгэв. Төлөвлөгөөт онд олборлолтод өртсөн талбайд дүүргэлт хийх ажил гүйцэтгэсэн бөгөөд нийт 5,5 га талбайг хамарсан. Бид дээрхи ажлыг гүйцэтгэхдээ MNS5917-2008 стандартын дагуу гүйцэтгэсэн болно.

6.2 Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээх арга хэмжээ гэж олборлолтод өртсөн газрыг техникийн нөхөн сэргээлт хийж биологийн олон янз байдлыг хамгаалан сайжруулахад чиглэгдсэн менежментийн багц арга хэмжээ юм. Биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал сайжирсан байх нь энэхүү ажлын эцсийн зорилго болно. Нөхөн сэргээлтэд ашиглах тохиромжтой ургамал, байгалийн аясаар ургах чадвартай төрөл зүйлийг нутагшуулахыг зорьж ажилласан.

Энэ онд тус хөтөлбөрийн хүрээнд 3.2 га талбайг шимт хөрсөөр хучих ургамалжуулах ажил төлөвлөн хийж гүйцэтгээд байна. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага MNS5917-2008 станандартад заасны дагуу усалгаагүй нөхцөлд ургах чадвартай ургамал согооворыг тариалсан.



Зураг-7 Биологийн нөхөн сэргээлт хийхээс өмнө



Зураг-8 Биологийн нөхөн сэргээлт хийсний дара

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлага гарч байна. Иймд 2012 онд УИХ-аас баталсан Байгаль орчныг хамгаалах тухай. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд дүйцүүлэн хамгаалах асуудлыг тусган өгч эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн.

Тус оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд тэр бум мод үндэсний хөтөлбөрийн дагуу Булган аймгийн Дашинчилэн суманд 2022 онд бид 6га талбайд нийт 20'000ш хайлаас модыг тарьсан. Хэдийгээр бид тухайн оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд 11000 мод тариалхаар төлөвлөсөн боловч сум орон нутгийн удирдлагын зүгээс тавьсан саналын дагуу нормоо давуулан биелүүлж тарьсан. Уг ажлын хүрээнд тус сумын зам дагуу нийт 1400м хашаа хаалт, гүний худгын мэрэгжлийн байгууллагаар гаргуулж сумын удирдлагуудад хүлээлгэн өгсөн. Мод тариалалтыг мэрэгжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу мэрэгжлийн тариаланч, компанийн ажилчидын хамт тариалсан болно. Тус ажилд нийт 163,5 сая төгрөг зарцуулсан.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус уурхайн хэмжээнд малчидын өвөлжөө барилга байгууламж байрладаггүй тул тус хөтөлбөр нь хамааралгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уг тусгай зөвшөөрлийн талбайд цаашид хийх геологи хайгуулын болон олборлолтын явц түүний дэд бүтцийн барилгажилтын ажил гарах нөхцөлд эртний түүх соёлын ямар нэгэн дурсгал өртөхөөргүй болсон тул 2022 онд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй болно. Мөн цаашид ажлын явцад түүх соёлын өвийн ямар нэгэн илрэл гарсан тохиолдолд холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэж хүндэтгэн харьцах болно.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-3 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төлөвлөлт болон гүйцэтгэл

Болзошгүй аюулосол, сөрөг нөлөөлөл	Урьдчилансэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг Нэгж Нийт	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэл	
				Хэрэгжүүлсэн ажил	хувиар
Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар нийт ажиллагсадын дунд сургалт зохион байгуулах	ХАБЭА-ын зардалаар	Жилд 1 удаа	Бид үйл ажиллагааны явцад батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулан мөрдлөг болгон ажилласан бөгөөд ажлын талбарыг хамгаалалтын зурвас татаж ажиллав. ХАБ-ын анхан сургалт нийт ажилчидад тогтмол өгч ажиллав. Ажиллах нийт хугацаанд аваар осолгүй ажиллаа. Мөн цаг агаарын нөхцөл байдалд уялдуулан ажиллах зорилгоор цаг агаарын урьдчилсан мэдээлэлийг гаргаж ажиллав.	100
	Уурхайн цогцолборын болон хаягдлын сангийн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах		Уурхай эхлэхийн өмнө		
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гэнэтийн аваар ослын үед шаардлагатай гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэгтэмдэглэгээг байршуулах		Жилд 1 удаа		100
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж Ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт	Жилд 1 удаа	100		

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төлөвлөлт болон гүйцэтгэл

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төлөвлөсөн төсөв Мян.төг	Гүйцэтгэл тайлбар	Төсөвт өртөг
Ахуйн гаралтай хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлыг өмнөх онд бий болгосон хогийн цэгт төвлөрүүлэн хуримтлуулах	-	Бид үйл ажиллагааны явцад үүссэн хог хаягдалыг түр хадаглах цэгт хуримтлуулав	-
	Хог хаягдлын гэрээг СЗД-тай байгуулан ажиллах, хог хаягдлын төлбөрийг цаг тухайд нь төлөх	200.0	Орон нутагтай хог хаягдалын гэрээ байгуулж гэрээний үүрэг бүрэн биелүүлж ажиллав	600.0
	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж журмын дагуу ангилж хадгалах, эх үүсвэрээс зайлуулах арга хэмжээнүүдийг авч ажиллах	200.0	Ахуйн хог хаягдалаас хуванцар болон дахин боловсруулах хог хаягдал тогтмол ялгаж хадаглав.	200,0
Үйлдвэрийн гаралтай хог хаягдал	Хоосон чулуулгийн хаягдлыг өмнөх онд бий болсон карьерийг булах, нөхөн дүүргэх ажлуудыг зохион байгуулж ажиллах	ҮАЗардал	Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэв .	
Аюултай хог хаягдал	Санамсар болгоомжгүйгээр ШТМ болон бусад аюултай шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай асгарсан тохиолдолд даруй тухайн хөрсийг хуулан авч, саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах.	350.0	Үйл ажиллагааны явцад асгаралт бүртгэгдээгүй болно.	
	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлүүдэд ашиглагдсан аккумулятор, тос, тосны шүүр, фильтр зэргийг тусгайлан ангилж, агуулахад хадгалах ба тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс нь аюулгүйгээр зайлуулах	100.0	Бид хөрс уулын ажлыг гэрээт компаниар гүйцэтгүүлсэн бөгөөд үйл ажиллагааны явцад үүссэн аккумулятор зэргийг буцааж тушаах арга хэмжээ авч чиглэл өгч ажиллав	
Дүн		850.0	800.0	

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараахи ажлуудыг төлөвлөн гүйцэтгэв.

Хүснэгт- 5 Удирдлага зохион байгуулалтын зардал гүйцэтгэл

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2022 он	Гүйцэтгэл
1	Сум.багийн удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Тухайн үед төлөвлөж зарцуулах	2022 онд	Цар тахалын нөхцө байдлаас шалтгаалан орон нутгийн иргэдэд тайлагнах ажил гүйцэтгээгүй боловч орон нутгийн болон төрийн байгууллагад тогтмол мэдээ тайлан хүргүүлж ажиллав.
2	Тус уурхайд ажиллаж байгаа ажилчдыг сургалтад хамруулж мэргэшүүлэх, чадавхийг нь дээшүүлэх	500.0	2022 онд улирал бүр	Ажиллах хугацаанд ХАБЭА болон байгаль орчны чиглэлээр тогтмол заавар зөвлөмж өгч ажиллав.
3	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын Хувцас хэрэгслээр хангах	ХАБЭА-ын зардлаар	2022 онд улирал бүр	Нийт ажилчидыг хувцас хэрэгсэлээр хангаж тогтмол хэрэглэж хэвшүүлэв
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	800.0	2022 онд улирал бүр	Цар тахалын нөхцөл байдалд уялдуулан тогтмол шинжилгээнд хамруулж ажиллав
5	БО-ны аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар <u>гэрээлэн хийлгэх</u>	ҮАЗ	2022 оны 3-р улирал	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв.
7	Дараа жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний тайлан гаргах, дүгнэлт гаргуулах, дараа жилийн төлөвлөгөөг	2 000,0	2022 онд сүүлийн улиралд	Холбогдох журмын дагуу боловсруулсан
	Нийт	3 300.0		10000.0

13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан гаргаж мэдээллэж байсан болно.

14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасны дагуу хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн бүр дээр хяналт шинжилгээг хийж гүйцэтгэлээ. ОХШинжилгээний хөтөлбөрийг 5 болон 9 дүгээр сард Булган аймгийн УЦУОШГазрын Лабратори гүйцэтгэсэн бөгөөд мониторингийн судалгаагаар “Доргонт Улаан ухаа” уурхайн хэмжээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлс хүрээлэн буй орчинд зөвшөөрөгдөх стандартаас давсан үзүүлэлтгүй гарсан.

Шинжилгээний хариуг хавсаргав.

15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, гүйцэтгэл

№	Арга хэмжээ	Төлөвлөлтийн төсөв /мян.төг/	Гүйцэтгэл төсөв /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 600.0	3 300
2	Нөхөн сэргээлт хийх, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	18 500.0	60 000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3 000	163 500
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-ын зардал	
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	850.0	850
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	1 100.0	2 400
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	3 300.0	10 000
10	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад <u>тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь</u>	100.0	100
2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		25 450.0	240,15

ДҮГНЭЛТ

“БАТБРОДЕРС МАЙНИНГ” ХХК нь Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших MV-022121 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Доргонт Улаан ухаа” ордод 2022 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө БОМТ-г үндэслэл болгон хөтөлбөрт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажилласан болно. Бид байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 25,450 сая төгрөг зарцуулхаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл зардал нь **240,15** сая төгрөг бөгөөд нөхөн сэргээлтийн арга хэмжээнд байгууллагын бүх шатанд ач холбогдол өгч ажиллаж техникийн нөхөн сэргээлт болон биологийн нөхөн сэргээлт 100%-ийн биелэлттэй байна.

Төлөвлөгөөт онд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг шат дараалаттай бүрэн гүйцэтгэж үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг Булган аймгийг УЦУОШГазрын лабораториор гүйцэтгүүлэв. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө бүрэн биелсэн гэж үзэж байна. Бид цаашдын үйл ажилгаанд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээнд нэн шаардлагатай ажлуудыг тусган бүрэн гүйцэтгэж , нөхөн сэргээлтийг ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч ажиллана. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 тоот журмын дагуу боловсрууллаа.

Хавсралт

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
3. ОХШинжилгээний хөтөлбөр хөрс ус агаарын шинжилгээ хариу
4. Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны нүүр
5. Ус ашиглах дүгнэлт
6. Усны гэрээ
7. Барьцаа төлбөр төлсөн баримт